

II АНГИЙН “ХҮН-ОРЧИН” ХИЧЭЭЛИЙН ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН

ЗАСАН САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨР

Сэдэв: Амьд бие

Зорилго: Амьд ба амьгүй биеийг ялгах, амьд биеийн шинжүүдийг мэддэг болох

Зорилт:

- Хүүхэлдэй ба хүүхдийг ажиглаж адил ба ялгаатай шинжүүдийг тодорхойлох
- Амьд биеийн үндсэн шинжийг хүүхэд дээр ярилцаж гаргах
- Амьд биеийн шинжийг сурагчдаар нэрлүүлэх
- Амьд биеийг ялгаж будах, шинжийг нь бичих
- Үзсэн хичээлээ нэгтгэн дүгнэж ярилцах


Арга зүй:

- Харьцуулан жиших арга
- Тайлбарлан ярих
- Санал бодлоо солилцох
- Хосоороо ажиллах арга

Хэрэглэгдэхүүн: амьд биеийн зураг, зурган тест, РРt, хүүхэлдэй, өнгийн харандаа, инээсэн ба уурласан смайл, тасалгааны цэцэг, савх, хүснэгт

Хичээлийн явц:

Хичээлийн элементүүд	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйлл ажиллагаа	Анхаарах зүйл
Сэргээн сануулах үе 6 минут	○ Багш хүүхэлдэй ба сурагчдаас 1 охиныг сонгон авч юугаараа адил болох, юугаараа ялгаатай болохыг асууж ярилцана.	○ Сурагчид хүүхэд ба хүүхэлдэйн тоглоом 2-ыг ажиглан ялгаатай ба төсөөтэй шинжүүдийг хэлнэ.	Хүүхэд бүрт инээсэн уурласан смайл тарааж өгч тайлбарлаж өгнө. Хичээлийн үе шат болгонд смайлаа өргөнө гэдгийг сануулж хэлнэ.
Мэдлэг бүтээх үе 15 минут	○ Амьд бие ямар шинжтэй болохыг хүүхэд дээр ярилцаж сурагчдаар өөрсдөөр нь гаргуулна. Ингэхийн тулд хүүхэлдэй, охин 2т адил заавар өгнө. -алхаарай -дуулаарай -нүдээ хөдөлгөөрэй - бос, суу, гараа өргө, - Хэн нь багшийн хэлсэн үйлдлүүдийг сайн гүйцэтгэсэн бэ?	Адил зүйл: Хоёулаа гартай, хөлтэй, ам, хамар, нүд, чихтэй юм байна гэх мэт. Ялгаатай зүйл: ○ Нэг нь амьд, дуугардаг, хөдөлдөг, амьсгалдаг, хооллодог г.м ○ Хувцас, үс, нүдний өнгө нь өөр байна гэх мэт. -Охин сайн гүйцэтгэсэн. Амьтай болохоор.	-Амьд бие үхнэ гэдгийг шарлаж унасан навч дээр ярилцана. -Сурагчдаас ирэх хариултыг сайтар тооцно.

	Яагаад? -Хүүхэлдэй яагаад хийж чадахгүй байсан бэ? -Охин ямар ямар үйлдэл хийсэн бэ? -хүүхэлдэй ба охины өсөлтийг харуулсан зураг харуулж ярилцана. - Баг бүрт амьд биеийг шинжээр нь харгалзуулан холбох дасгал өгнө. -Эдгээр үгсээс юуг? ажигласан бэ? Амьд биеийн шинжүүд юм байна. Нэрлээрэй..... - Амьд бие ямар ямар шинжүүдтэй болохыг слайд дээр харуулж ярилцаж байх явцдаа самбарт шинжүүдийг бичсэн тулгуур дохиог байрлуулна. Амьсгална, хөдөлнө, хооллоно, өснө, үржинэ, үхэж, мөхнө	-Хүүхэлдэй амьгүй учир..... -алхсан, боссон, суусан -хүүхэлдэй амьгүй учир өсөөгүй. -охин амьд учир өссөн. Багууд хамтарч ажиллах Хөдлөх идэх, уух Хооллох хатах, үгүй болох Өсөх алхах, гүйх, суух Үржих ургах, томрох Үхэх, мөхөх олон болох, Гүйцэтгэсэн даалгавраа тайлбарлана. -Амьд биеийн хийж байгаа үйлдэл байна.... амьсгалах, хөдлөх, хооллох..... -Багшийн харуулж буй слайд дээр харилцан ярилцана. Багшийн харуулж буй зургуудыг тухай бүрд нь сайн ажиглаж ярилцаад шинжүүдийг тодорхойлж дэвтэртээ бичнэ.	Амьд биеийн хамгийн чухал зүйл амьсгал гэдгийг ойлгуулахдаа амыг нь жимийлгэж хамрыг нь чимхүүлж үзүүлнэ.
Бататгах үе 8 мин	<u>Туршилт 1:</u> Амьсгална гэдгийг сурагчдыг хамрыг нь чимхүүлж амыг нь жимийлгэнэ. -Та нарт юу мэдрэгдсэн бэ? Алжаал тайлах тоглоом тоглоно. Зургуудыг ажиглаад амьд бие бол алгаа 1 таших, амьгүй бие бол 2 гараа өргөнө гэдгийг хэлнэ. <u>Туршилт 2:</u> Навч хэмжих туршилт : Ургамал өсөх үйл ажиллагаа  Тэмдэглэсэн сар өдрөө тэмдэглэнэ. 7 хоногийн дараа дахин хэмжинэ гэдгээ хэлнэ.	-Туршилтыг багшийн хэлсэн зааврын дагуу хийнэ. -Амьсгалж чадахгүй байна. -Багшийн зааврын дагуу тоглоомыг тоглоно. Туршилтыг багшийн зааврын дагуу гүйцэтгэнэ. Сурагчид хосоороо тасалгааны цэцгийг савх модоор хэмжиж хүснэгт дээр тэмдэглэнэ. Тэмдэглэсэн сар өдрөө тавина.	Алжаал тайлах тоглоомын зааврыг сайн танилцуулж хөдөлгөөнийг хийлгэнэ. Навч хэмжих аргачлалыг сайтар тайлбарлана.
Үнэлгээ, дүгнэлт 5 минут	Сурагч бүрт зурган тест өгч амьд биеийг ялгаж тэмдэглэгээ хийх ба	-Багшийн өгсөн зурган тестийг ажиглаж амьд биеийг ялгаж тэмдэглээд хүснэгтэнд амьд	Сурагчид үзсэн хичээлээ нэгтгэн дүгнэхэд тусална.

	хүснэгтэнд тухайн амьд биеийнхээ 1,1 шинжийг бичих дасгал ажиллуулна. ○ Самбарт байгаа тулгуур дохионуудыг харж хичээлээ дүгнэж ярилцана. ○ Сурагчдаар смайлыг өргүүлж хичээлээ үнэлнэ.	биеийн 1 шинжийг бичнэ. -Самбарт байрлуулсан тулгуур дохионуудыг ажиглан хичээлээ хамтран ярилцаж дүгнэнэ.	
Гэрийн даалгавар 1 минут	Сурагчдад нэг үр өгч хамтарч суулгаад 7 хоног ажиглах даалгавар өгнө.	Гэрийн даалгавраа тэмдэглэж авна.	

САМБАР ТӨЛӨВЛӨЛТ

САР ӨДӨР

Хичээлийн сэдэв

Тулгуур дохио ба зураг

Амьд биеийн шинжүүд

Амьсгална

Хөдөлнө

Хооллоно

Өснө

Үржинэ

Үхэж мөхнө

Зурган тест

нөхөх тест

Будсан зурган тест

Цахим дэлгэц